

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ЭНЭТЭМБЕР УХЛААНЫ ФАКУЛЬТЕТ

ТҮҮЖ

ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ № 488 (14) 2002 он

RUSSIA



INDIA

Гарчиг

Эрхэм уншигч Танаа

5

Монголын түүх

1. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. 8
2. Д.Хүүхэнбаатар, П.Дэлгэржаргал. Монголын үндэсний нэгдэх хөдөлгөөний түүхийн асуудал. (XX зууны эхний хагас). 12
3. Д.Энхцэцэг. Үндэсний эв нэгдэл- тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн баталгаа болох нь. 18
4. Ж.Урангуа. XX зууны эхэн үеийн Ар Монгол дахь гадаадынхны үйл ажиллагаа. 23
5. З.Лонжид. Дундат иргэн улсаас Монголын тухай баримталсан бодлогыг нэхэн судлахуй. (1919 оноос хойш) 29
6. С.Отгонжаргал. XX зуунд Монголд гарсан хөрөнгөлөг ардчилсан хувьсгалын асуудалд. 34
7. Н.Хишигт. Монголын түүхэнд Барон Унгерний холбогдох нь /1921-1925/ 42
8. Б.Пунсалдулам. Монгол дахь Буриадын хурал. 51

Монголын шашин, соёл, сэтгэлгээний түүх

1. Б.Ралгаа. Монгол оронд бурханы шашин дэлгэрсэн нь. 57
2. С.Түвшин. Ж.Цэвээний улс төр, нийгэм-эдийн засгийн үзэл баримтлалын тухайд. 68
3. З.Баасанжав. МУИС байгуулагдсан түүхээс. 73
4. Л.Ариунаа. Монголд өөрөө удирдах ёсны түүхэн уламжлал байсан уу? (Бодрол, тэмдэглэл). 78

Байгаль хамгаалах түүхэн уламжлал

1. Ж.Болдбаатар, С.Дэмбэрэл. Монголчуудын байгаль орчноо хамгаалах зан заншил, хууль тогтоомжийн түүхэн тойм (Нэн эртнээс XX зуун). 80
2. Л.Чулуунбаатар. Ган зудын гамшиг, гэтлэн давах арга замын тухайд. 99

Гадаад харилцааны түүх

1. Ута Шёне. 1920-иод онд Герман улсад суралцаж байсан монгол сурагчдад болон Лайпцигт хэвлүүлсэн монголын газрын зургийн түүхэнд холбогдох зарим тэмдэглэл. 104
2. Р.Төрдалай. Франц улсын Парис хотын монгол сурагчид /Түүхэн тэмдэглэл/. 110

Түүх бичлэг

1. Удо Баркманн. Монголын түүхийн талаархи олон улсын судалгаа: Эзгүйрэл, улс төрийн ашиг хонжоо хоёрт идэгдсэн Монголын түүх. 114
2. Б.Пунсалдулам. 1911 оны үндэсний эрх чөлөөний хувьсгалын удирдагчдын тухай түүх бичлэгийн зарим асуудалд. 127

Түүхэн газар зүй

1. Д.Сүхбаатар. Монгол орны түүхэн газар усны нэрийн тухай. 133

Хавсралт

1. Түүхийн салбарыг төгссөн алдартнууд 137
2. Зохиогчдын товч танилцуулга 139

Монгол дахь Буриадын хурал /1921-1925/

Докторант Б. Пунсалдулам /МУИС/

Буриад Монголчууд нь өнө эртнээс харилцаатай, угсаа гарал нэгтэй, ахан дүүс билээ. Буриадчууд Халх Монгол руу нүүх, дүрвэн орох явдлыг судлаачид үндсэн 4 үе шатад авч үзсэн байдаг (3;5) Эхний нүүдэл 1900-1907 он, хоёр дахь нүүдлийг 1910-1912 он гуравдахь нүүдэл / хамгийн өргөн далайцтай / 1918-1922 дөрөвдэх 1927 он гэж үздэг.

Энд бид анх ардын засгийн анхны жилүүдэд Монголд нүүдэллэн ирсэн Буриад нарын талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг цухас төдий авч үзэхийг зорьсон билээ.

1921 оны 11-р сарын 6-нд Монгол Орос улсын хооронд найрамдлын гэрээ байгуулах үеэр Монгол улсын төлөөлөгчдийн тэргүүн С. Данзан (1885-1924) Оросын харьяат Буриадчуудыг хүсэлтээр нь Монголын харьяат болгох санал тавьж байжээ.

Уул хэлэлцээр дээр Оросын төлөөлөгчдийн тэргүүн С. Духовский "... Орос улсын харьяат Буриадчууд хүсэлтээ илэрхийлэх аваас Монголын төлөөлөгчдийн дэвшүүлсэн санал Оросын хөдөлмөрийн олон түмний энхийн хүсэл эрмэлзэлтэй нийцэж байна хэмээн" мэдэгдсэн. Ингэж Ардын засгийн жилүүдэд Монголд нүүдэллэн ирсэн Буриадчуудын асуудал нааштайгаар шийдвэрлэгдэх үндсэн тавигджээ.

Монголын ардын засгийн газрын өгсөн чиглэлийн дагуу Монгол газар нүүдэллэн ирсэн Буриад нарын захиргаа байгуулж, аж байдлыг тохижуулах ажил 1921 оны 12 сараас эхлэн яригдах болжээ.

Олноо өргөгдсөний 11-р оны 12 сарын 24 нд / европын 1сарын 22 / Нийслэл Хүрээнд Буриад нарын 1-р хурал болсон байна. Энэ хурлаар Монгол дахь Буриад нараас нутгийн монголчуудтай харилцах, нутгийн захиргаа байгуулах, буриад нарыг тохинуулах зэрэг таван асуудал хэлэлцсэн бөгөөд энэ хуралд 30 хүн ирж хурлын даргаар Цэдэн-Иш/ Гочитский /, нарийн бичгийн даргаар Бадамцэрэн Балсанов, Цэвэгжав, Даши нарыг сонгожээ. / УТТА-Ф37.Д.1. ХН- 21 /

Олноо өргөгдсөний 11 оны 12 сарын 25-ны өдөр Гадаад яамнаас Нийслэл хүрээнд байрлаж байсан Буриад нарын ахлагчид 172 тоот албан бичгээр мэдэгдэл өгч, Монгол улсад дагаар орсон Буриад нарын хурлын газар байгуулахыг зөвшөөрсөн байна.

Энэ дагуу 12 оны /1922/ цагаан сарын шинийн 8-нд / европын 2 сарын 05 нд / Нийслэлд суугаа Буриад нарын 35 хүн хуралдсан энэ хурлаар тус газар нүүдэллэн ирсэн Буриад нарыг тохинуулах, Буриадын эрх үүргийн тухай, Буриад нарын дотор захирах газар байгуулах, аж ахуй эрхлэх, захирагдах эрхийг Монголын ард лугаа нэгэн адил болгох Буриад нарыг үлэмжхэн тоогоор суурьшсан газар аймаг хошуу зэрэг өөрийн захиргаа, газруудыг байгуулах зэрэг нилээд асуудлыг хэлэлцжээ. Мөн хурлаас дээд газарт хүсэлт болгосон зүйлээс үзэхэд: Ардууд тээвэр хийх, хашаа байр барихад гааль түрээсийг хөнгөлөх, өөртөө улааны албыг хөнгөлттэй байлгах, шүүхэд буриадын төлөөлөгчийг оролцуулах хүрээнд буриадын хурлын газар байгуулах хүсэлтээ илэрхийлээд дээрх хэлэлцсэн асуудлыг дэлгэрүүлэн боловсруулах комиссийг найман хүний бүрэлдэхүүнтэй байгуулж Цогтбадамжав, Цэдэн- Иш, / Гочитский/ Батхаан, Бадамцэрэн, Бадмаев, Мүнхүев, Цэвэгжав, Юмтаров нарыг сонгосон байна.

Олноо өргөгдсөний 12 оны / 1922 / цагаан сарын 10-ны өдөр Монгол газар нүүн ирсэн Буриадын хэрэгт түр сонгогдсон комиссийн хурал болсон. Комиссийн

хурлын 1-р бичигт Буриадын хурлын газар нь засгийн газрын хэлтэст туслах, буриадын захиргаа байгуулах удирдах газартай холбоо тогтоох, найрамдалыг эвдэхгүй байх нутгийн монголчуудтай найрамдалтай байх, чухал зүйл тохиолдвол Монголын хязгаар нутаг, шашин, ардын засгийг хамгаалах хэрэгт зүтгэнэ гэжээ.

Мөн хурлаас Буриадын хурлын газрын гишүүдийг Цогтбадамжав Дашбалын Цэдэн-Иш, Дашийн Цэвэгжав нарыг, орлогч нарт Ринчинов Баторон нарыг сонгожээ.

"Ардын засгийн газрын бичиг Олноо өргөгдсөний 12 он хаврын илүү тэргүүн сарын 19 / өвропын 3 сарын 17 / өдрийн засгийн газрын 10-р хурлын 3-р зүйлд хэлэлцээд харьяат комиссоос Монгол газар нүүдэллэн ирсэн Буриадыг тохинуулах тухай эл төлөвлөсөн нь гүнээ бодол хийлсэн маш зүйтэй байх тул цөмийг есоор болгож баталсныг зохих газруудад явуулан тушаан дагаж шийдвэрлүүлэхээр тогтов". 12 оны 4сарын 26 дугаар 82 гэсэн баримт байдаг.

Ийнхүү 12 оны 3 сарын сүүлчээр Нийслэл хүрээнд Буриадын хурлын газар байгуулагдаж, 12 оны 4сарын 14-ний засгийн газрын 16-р хурлын 6-р зүйлд хэлэлцээд Дотоод яамнаас эрхлэн Буриадын газарт хэрэглэх тэмдгийг гуулиар цутган үйлдэхээр тогтсон бөгөөд уул тэмдгийг 12 оны 5 сарын 26нд Буриадын хурлын газарт хүргүүлсэн байна. Энэ үеэс Нийслэл хүрээнд Буриадын хэргийг эрхэлсэн Буриадын Хурлын газар албан ёсны үйл ажиллагаа эхэлжээ гэж үзэж болохоор байна. Энэ бол Монголд нүүдэллэн ирсэн Буриадын хэргийг эрхэлэн явуулах төв удирдах газар байв.

Буриадын хурлын газар нь одоогийн Дүрслэх урлагийн музейн урд, Христосын сүмийн зүүн талд Буриадуудын албан татварын мөнгөөр Буриадуудын барьсан Орос хийц загварын модон байшинд үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Хурлын газар нь дарга, нарийн бичгийн дарга, орчуулагч бичээч, галч гэсэн орон тоотой ажиллаж, хошуудын албан татварын мөнгөөр санхүүжиж байв. Хурлын анхны даргаар Ерөө голын хошууны Дашбалын Цэдэн-Иш сонгогдон ажиллаж байв. 1923 оноос Буриадын хурлын даргаар Бадамын Дугаржав ажиллаж байжээ.

Буриадын хурлын үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хуралдаан байв. Хурлууд нь байнгын ажиллагаатай биш боловч тодорхой хугацаанд хуралдаж байсан.

Буриадын хурлын тогтолцоо нь багийн хурал, сумын хурал, хошуудын хурал, Нийслэлийн Буриадын хурал гэсэн шатлалтай байв.

Буриадын хурлын эрх зүйн үндэс нь ардын засгийн газраас баталсан "Ардын засгийн газрын хурлын түр дүрэм" "Улсын түр цагийн хурлын дүрэм" "Тангарагийн гэрээ" буюу 1923 онд батлагдсан "Улсын хурлын дүрэм" "Улсын хурал хуралдах заавар" зэрэг засаг төрийн эрхийн холбогдолтой дүрмүүд байв. Эдгээр дүрэм нь Буриадын хурлын эрхийн үүсэл хөгжил бэхжилтэд их нөлөө үзүүлсэн байна.

Буриадын хэргийг эрхлэх Хурлын газар нь Монголд ирсэн Буриад нарын дагаар орох асуудлыг боловсруулан Монголын харьяат болох тодорхой засаг захиргаатай болох хүртэл ажиллах түр байгууллага байсан юм.

Буриадын хурлын зорилт нь: Буриадын хүн ам, мал хөрөнгийн бүртгэлийг явуулах шинээр байгуулах, түр хошуу, сумдыг засгийн газрын удирдлагын дор зохион байгуулж тэдний дотор захиргаа, аж ахуй, худалдаа, соёл хүмүүжлийн ажлын талаар хошуудын захиргааны ажлыг чиглүүлж холбогдох асуудлаар ардын засгийн газрын яамдтай шууд харилцаж тусламж дэмжлэг аван ажиллаа явуулахад оршиж байжээ.

Энэ дагуу буриад нарыг тохижуулах, хошуу сум байгуулж, захиргааг бэхжүүлэн дагаар орсон Буриадын дотор захирах захирагдах ёсыг мөрдүүлж танхай балмад явдал, тусгай дээрмийн хэрэгт хатуу тэмцэл хийж хошуудын захиргааг чиглүүлж байжээ. Мөн цагаан намын харгис дээрэмчдээс Буриад нарыг хамгаалах хэрэгт ардын засгийн газрын цэрэг дотоод шүүх яамны дэмжлэг авч устгуулах ажлыг хийж байв.

Монгол газар бүхий Буриад нарын хоёрдугаар хурал 1922 оны 7-сарын 12-ны өдөр болж харьяатаар бүртгэгдээд байсан 1624 өрх айлыг төлөөлж ирсэн 45 төлөөлөгч хуралд оролцсон байна.

Буриадын энэ хуралд Зөвлөлийн засагт Орос улс ба Алс Дорнодын БНУ-ын бүрэн эрх барих элчин сайд Леоберцов, МАН-ын Төв Хорооны дарга Ц. Дамбадорж, Ардын засгийн газрын нарийн бичгийн дарга Г.Навааннамжил, Монгол Ардын бүх цэргийн жанжин бөгөөд цэргийн яамны тэргүүн сайд Д. Сүхбаатар Монголын ХЗЭ-ийн Төв Хорооны тэргүүлэгч С. Буяннэмэх нар оролцож үг хэлсэн байна.

Энэ хурал зохион байгуулалтын асуудал хэлэлцэж, хурлын даргад Дашбалын Цэдэн-Иш дэд дарга Бадамын Бат, нарийн бичгийн даргад Балжины Бадамцэрэн, Баламын Аюуш, Жамбалын Сандаг, Цэрэнжавын Цэдэн, Гомбын Цэвэгмэд нарыг сонгожээ.

Буриадын төлөөлөгчдийн хоёрдугаар хурал тухайн цагийн байдал, Монгол газар нүүдэллэн ирсэн Буриад нарыг хэрхэн тохинуулах, уугуул монголчуудтай хэрхэн харилцах, Буриад нарын эрх үүргийн тухай зэрэг гол гол үндсэн асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гаргаж байв.

Эдгээр Буриадын хурлын шийдвэрийг ардын засгийн газар хянан үзэж, Буриад нарын хүсэлтийг хүлээн авч тэднийг тохинуулах ажлыг эрэмбэ дараатай зохион байгуулжээ.

Буриад нарт саналынхаа үндсэн дээр Монголын харьяат болж дагаар ороход нь туслах, дагаар орсон Буриад нарт хадлан бэлчээр, ой мод, ус бүхий нутаг газар олгож, Буриад нарын дотор нутгийн захиргаа байгуулах, Буриад нарын аж байдлыг тохижуулахад албан татвар ба өртөө цэргийн албанаас зохих хугацаагаар чөлөөлөх зэрэг чухал чухал арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж байв.

Юуны өмнө, нутгийн захиргааны үүргийг дээшлүүлж бэхжүүлэхэд анхаарал тавьсан. “23 оны 2сарын17нд Ардын засгийн газрын 175 тоот бичиг дагалдуулан Буриадын зургаан хошууны тэмдгийг модон тэмдэг /сүүлд жинхэнэ хошуу болсны дараа ган болд тамга өгсөн./ Буриадын хурлын газарт хүргүүлсэн бөгөөд эдгээр тэмдгийг мөн оны 3сарын эхээр зургаан хошуунд хүргэсэн. /УТТА. Ф37.Д I ХН-3 /

Эдгээр зургаан хошууг тодруулбал:

1. 12 онд Сэцэн хан уулын аймгийн нутагт Улз голын хошуу одоогийн Дорнод аймгийн Дашбалбар, Баяндун, Баян-уул сумынхан. 1924 оны үед 1300 өрх, 3900-4200-ын дотор багтах хүн амтай. Улз голын хошуу анх 1922 онд байгуулагдахдаа Баяндун, Багин, Баянзүрх, Баян уул, Дэлгэр уул, Зүүн тарни, Улз гол, Хөх уул, Хан уулын зэрэг 9 сумтай байжээ. Эдгээр нь ихэвчлэн Ага нутгаас нүүж ирэгсэд байсан. Үүнд 1297 өрх, 5982 хүн ам байв.

2. Онон голын Буриад хошууг мөн Сэцэн хан уулын аймгийн нутагт 12 онд байгуулсан. / Одоогийн Хэнтий аймгийн Дадал, Биндэр, Бат-ширээт сумынхан/ 1923 оны үед 1000 өрх, 3000-3500 хүн амтай байсан. Онон голын Буриад хошуу нь Баян, Баянхан, Балж гол Батсүмбэр, Онон гол, Цагаан нуур Шар булаг, гэсэн долоон сумтай байв. 1931 онд Хэнтий аймаг байгуулагдахад Балж, Баян, Онон, Дадал, Биндэр, сумд болсон. 1934 онд Балж Баян, Онон, Дадал, Бидэр, суманд

шилжүүлжээ. 1952 онд Биндэр сумын 5 багаар голлуулан Бат-Ширээт сумыг байгуулав.

3. 1923 онд Халх нөмөргийн хошууг сэцэн хан уулын аймгийн нутагт (одоогийн Дорнод аймгийн Цагаан овоо сумынхан) анх Могойт гол, Нөмрөг гол, Халх гол гурван сумтай байгуулсан. 1929 онд Манлайбаатар вангийн Амгалан хан уулын хошуу Улз голын хошуудтай нийлжээ. Энэ хошууны Буриадын гарал Хорь-Агын болон Читийн Тарим нутгаас ирэгсэд байв. 450 өрхтэй, 1350-1800-аад хүн амтай байсан. 1931 онд Дорнод аймаг байгуулагдахад тус аймгийн Буйр, Түмэндэлгэр, Хулстай, Эрдэнэ-цагаан зэрэг сумдад сууж байгаад 1936 онд Цагаан овоо гэх нэгэн шинэ сум байгуулж дээрхи сумдад тархсан Буриад ардыг нэгтгэн суулгажээ.

4. Богд хан уулын аймгийн нутагт 12 онд Ерөө голын хошууг / Одоогийн Сэлэнгэ аймгийн Ерөө суманд голлон суудаг./ байгуулсан. 400 гаруй өрх, 1200-1500 гаруй хүн амтай. 1922 онд анх Баянгол, Алтанбулаг, Галдтай гэсэн гурван сумтай байгуулагдсан.

5. Богд хан уулын аймгийн нутагт 13 онд Малгар уулын хошууг / Одоогийн Төв аймгийн Мөнгөнморьтын Буриадууд/ байгуулсан. Дотроо Мөнхжаргалант, Ногоон нуур, Номгон нуур гурван сумтай байв.

6. Түшээт хан уулын аймагт 13 онд Эг-Сэлэнгийн хошууг байгуулсан. Тэшиг хавийн / Булган аймгийн/ Үүр голын Сэлэнгийн Буриадыг оруулдаг. 270-300 орчим өрх, 1200 гаруй хүн амтай байжээ.

Ардын засгийн газар орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтад тун болгоомжтой хандаж уян хатан тактик баримталж байв.

Энэ асуудлыг боловсруулах комиссийг 1921 оны эцсээр байгуулж тэр комисс нь "Монголын хэмжээт цаазат засгийг тогтоох гол утгын бичиг"-ийг боловсруулан гаргасан. Энэ бичигт нутгийн захиргаанд бүх шатны хурал байгуулах, угсаа залгамжлах ёсыг устгаж аливаа язгуурын ялгааг халж, бүгдийг сумын ардын тоонд оруулах зэрэг олон чухал үндэслэл тусгагдсан.

Энэ дагуу орон нутгийн засаг захиргаадыг өөрчлөх эрх зүйн үндсийг боловсруулах ажлыг явуулж, ардын засгийн газраас " Монголын олон засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм" /1923/ "Их шавийн захиргааны дүрэм" /1923/ " Ховдын харъяат газрын дүрэм" зэргийг батлан гаргасан. "Нутгийн захиргааны дүрэм ёсоор Буриадын хурлын анхан шатны нэгж нь арван гэрийн хурлууд, дараа нь багийн, сумын, хошууны хурлууд байв. Хошууны хурал нь тус хурлаас доош шатны хурлуудын хэлцэж тогтоосон хэргийг дахин нягталж Нийслэл Хүрэн дэх Буриадын хурлын газарт оруулж байжээ.

Шат дараалан байгуулагдсан хурлууд нь нүүдэллэн ирсэн Буриадуудыг Монголчуудын адил төрийн удирдах хэрэгт татан оруулж эрх, үүргийг нь өндөржүүлсэн явдал байв.

13 оны 5сарын 22-ны өдрийн 1цагт Зөвлөлийн засагт Бүгд найрамдах холбоот улсын засгийн газар, Монгол ардын засгийн газраас томилогдсон комиссын 1-р хурал болж, Буриадыг Монголд дагаар орох асуудлыг хэлэлцэх комисс үүсгэж, уг комисс ажилдаа орсон.

Зөвлөлийн Засагт холбоот улсын талаас Монголд суугаа элчин сайд Юдин, гадаад яамны төлөөлөгч Амагаев, Монгол ардын засгийн газраас Данзан, Цогтбадамжав, Буриадын хурлын газраас Дашиев (зөвлөх эрхтэй) нарийн бичгийн дарга Миртенель, Санжайжамц нар орсон. Уг комиссын ажлын эхний хэсгийг элчин сайд Юдин даргалсан байна. [УТТА. Ф37.Д1 ХЧ-26]

Хоёр улсын комисс Буриад нарыг дагаар оруулах асуудлыг нарийн зарчмын үндсэн дээр шийдэгдэх нь чухал гэж үзсэн. Цаашид Буриадыг дагаар

оруулах, тохинуулах, зохицуулах асуудал комиссын хэлэлцэн тохирсоны дагуу шийдвэрлэгдэх болсон.

Үүнд: "Манай дотоод хязгаарын дотор тохиоход ялт хүмүүс хэрэг шийтгэн таслах, Орос улсын хувьсгалын газраас оноосон ялаас зайлсхийж, гадаадад нэвтэрсэн нь цөөнгүй болох агаад Монгол газар нүүн ирсэн Буриад Монголын дотор улс төрийн ба эрүүгийн хэрэгт холбогдох хүмүүсч мөн буй. Тус зөвлөлийн засагт Орос улс хэрэг шийдэх газраас зөвлөлийн засаг Орос улсаас Монгол газарт суугаа төлөөлөгчийн газраар дамжуулан бичиг ирүүлэхэд Монголын засгийн газар эрх биш тэдний ялт нарыг эргүүлэн өгөхийг хүснэ " гэжээ. [УТТА. Ф. I Д I ХН 18.X73]

Үүний хариуд Монголын ардын засгийн газраас манайх эргүүгийн хэрэгт холбогдсон хүмүүсийг дагаар оруулахыг үл дурлах тул, ийм хүмүүсийн нэрсийг дагаар орох явдлыг гүйцэтгэхийн өмнө элчин төлөөлөгчөөр дамжуулж ирүүлнэ үү гэсэн утгатай хариу өгсөн байна. Энэ тухай баримт [УТТА. Ф. I Д I ХН 4.X 86]-д бий.

Хоёр улсын хамтарсан комиссын хуралдаанаас хурлын шийдвэрийг хянах, хэрэгжүүлэх комиссыг томилж, энэ комисс нь орон нутагт очиж хошуу сумдыг шинээр эмхлэх зохион байгуулах, дагаар орохоор санал хүсэлтээ гаргасан, дагаар орохыг зөвшөөрсөн хүмүүсийг бүртгэн тэдэнд үнэмлэх бичиг олгох, буриад нарыг тохинуулах зэрэг бусад асуудлыг газар дээр нь зохион байгуулж гүйцэтгэсэн байна. [УТТА. Ф. I Д I ХН 1.X 33]

Гэсэн ч нүүдэллэн ирсэн Буриадууд Монголын шинэ харъяат иргэн болж, аж амьдралаа товхиуулан ардын эрхт төрийн үйл ажиллагаанд хурлаараа оролцож нийгмийн гишүүний эрх үүргийг хүлээж авсан юм. Тухайлбал энд улсын анхдугаар их хуралд төлөөлөгч сонгон сонгон оролцсон Их хурлын 77 төлөөлөгчийн дотор Буриад зургаан хошуунаас долоон төлөөлөгч оролцож, ардчилсан төрийнхөө дээд байгууллыг сонгож, анхны ардчилсан үндсэн хууль батлалцжээ.

Монголд дагаар орсон Буриад хошуудын илтгэлийг улсын анхдугаар хуралд Буриад хошууны төлөөлөгч / хурлын газрын дарга / Гомбын Цэвэгмид уншжээ.

Гомбын Цэвэгмид илтгэлдээ; 1914-1920 онд Орос орны дотор их хямрал байлдаан болоход бидний /Буриат нар-БП/ заримууд нь тэдний даширмаар амь бие алдах ба хөрөнгө хогшлоо сүйтгэх зэргээр их л гачигдалтай болсон учраас нэгэн язгуурыг үндсээ бодож, халх монголын нутагт дүрвэн нүүж ирсэн бөгөөд одоо гурван жилийн өмнө Монгол ардын гэгээн засаг мандаг түүний гавьяагаар эдүгээ хоёр жилээс нааш бидний Буриад нарыг тохижуулан төвхнүүлэх тухай нийслэлийн газраа тусгай эрхлэн хурлын газар байгуулсан бөгөөд, мөн онд хурлын газраас эрхэлж монголд нүүдэллэн ирсэн Буриад нарын хошуу байгуулж, дотоод яамнаас тамга олгож түр захиргаа байгуулсан. Өнгөрсөн 13 оны зун Орос-Монгол хоёр засгийн газраас тусгай комисс томилон гаргаж бидний дагаар орохыг шийдвэрлэсэн, гээд 1924 онд байсан өрх, амын тоог дурьдсан байдаг. [1, т-212]

Улсын Анхдугаар их хурал Монголд нүүдэллэн ирсэн Буриадуудыг Монгол улсын харъяат болгох эцсийн шийдвэр гарсан тул буриадын хурлын газрыг үүргээ гүйцэтгэсэн гэж үзээд, 1925 оны 4сарын 1-нд татан буулгасан.

Энэ асуудалтай холбогдуулан зургаан хошуунаас төлөөлөгч томилон хурлын газрын мөнгөн санхүүг шалгаж, зарлагаас үлдсэн мөнгөн хөрөнгө, хурлын газар хэрэглэж байсан ширээ сандал зэрэг буюу бусад хогшлыг Дотоод яамны харьяа эрүүлийг хамгаалах газар (комиссын 1925 оны 11 сарын 29-ний өдрийн

тогтоолоор) шилжүүлсэн байна. Хурлын газар татан буугдсаны дараа хошуудын нэрээс "Буриад" гэдэг үгийг хасаж шинээр тамга хийлгэж тараасан байна.

Монгол Ардын засгийн газар, Буриадын хурлын газраас авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд хошууд байгуулагдсаны дараа засгийн газрын 1924 оны 10 сарын 18-ны өдрийн 12 хурлаар 15800 хүн ам бүхий 4000 өрхийг, Улсын анх дугаар их хурлаар 16098 хүн ам бүхий 4316 өрхийг засгийн газрын 1926 оны 6 сарын 12-ны өдрийн 12-р хурлаар 3616 хүн ам бүхий 927 өрх / нийт дүнгээрээ 35514 хүн эхний гурван жилд элдэв татвараас чөлөөлж төвхнүүлжээ.

Буриадын хурлын түүхэнд холбогдох материал УУТА –ын сан хөмрөгийн 37-р фондод арвин их байна.

Ашигласан ном зохиол

1. БНМАУ-ын анхдугаар их хурал. эмхтгэсэн Д. Даш УБ., 1984
2. Болдбаатар Ж, Лүндээжанцан Д. Монгол улсын төр эрх зүйн түүхэн уламжлал УБ., 1997
3. Дамдинжав. Д. Монголын Буриад зон УБ., 2000
4. Монгол улсын төр эрх зүйн үндэс ред. Т. Сэнгэдорж. УБ., 1998
5. Нямаа А. Батцэцэг Ч. Орос дахь Монгол угсааны улсууд УБ., 1995
6. Сономдагва Ц " Монгол улсын засаг захиргааны зохион байгуулалтын өөрчлөлт шинэчлэлт " УБ., 1998
7. УТТА-ийн 37-р фонд